

ЯЛТНЫГ ӨӨРЧЛӨН НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХАМТЫН ОРОЛЦОО

COOPERATIVE EFFORT IN TREATMENT AND RE-SOCIALIZATION OF INMATES



Н.ГАНТУЛГА

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор (Ph.D), профессор, хурандаа

N.GANTULGA

Ph.D in Law, Colonel, Chief of the Court Decision Execution Institute, Law Enforcement University

Товч агуулга: Энэ өгүүлэлд манай улсын эрүүгийн болон эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн салбарт хэрэглэж буй “гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх”, “ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх”, “хорих байгууллага дахь нийгмийн ажил”, “ялтныг нийгэмшүүлэх” зэрэг нэр томьёо, мөн ялтны уулзалт, утсан харилцаа, гадагшаа явах чөлөөтэй холбогдсон тулгамдсан асуудлаарх судлаачийн байр суурь, үзэл бодлыг илэрхийлсэн. Ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр туурвисан өөрийн болон гадаадын (ОХУ, БНКаЗУ, ХБНГУ зэрэг) орны эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, эрх зүйн эх сурвалж, хууль зүйн практикийн мэдээллийг ашигласан.

Abstract: The specific problems in the field of serving sentences, such as ‘treatment of offenders’, ‘Behavioral impact on inmates’, ‘Social work at the correctional institutions’, ‘Socialization of inmates’ have been researched in the scientific report. Sources used in the report are originated from researcher’s own scientific work as well as literatures of foreign countries’ scientists, such as Russian Federation, Kazakhstan, and Germany.

Түлхүүр үг: Нийгэмших, нийгэмшүүлэх (социализация-орос, socialization-англи, sozialisierung-герман), өөрчлөн нийгэмшүүлэх, өөрчлөн нийгэмших (ресоциализация, resocialization, resozialisierung)¹, ялтны удаан, түр хугацааны уулзалт, ялтанд чөлөө олгох, ялтан захидлаар харилцах, утсан холбоогоор ярих зэрэг.

Key words: Socialization, resocialization, long and short term visitation, external leave, mailing, phone communication.

Бүтэц: Илтгэл нь оршил, гурван дэд хэсэг /“Нэр томьёоны асуудал”, “Ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх үндэсний эрх зүйн зохицуулалт, практикийн зарим асуудал”, “Олон улсын болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын анхаарал татсан асуудал”/, дүгнэлт-саналаас бүрдсэн.

¹ Илтгэгч “ресоциализация” гэсэн нэр томьёог ийнхүү хөрвүүлэн хэрэглэсэн ба цаашид ийнхүү хэрэглэж хэвшүүлэхийг санал болгож байна.



Хууль сахиулахын их сургууль

ОРШИЛ

Дэлхийн улс гүрнүүдийн төрийн бодлогын тогтолцоонд хорих ял, түүнийг оногдуулах, эдлүүлэх ажиллагаа онцгой байр эзэлдэг. Учир нь хорих ял хүний чөлөөтэй байх, чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох, гадаадад явах, хөдөлмөрлөх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, төрийг удирдах хэрэгт оролцох зэрэг үндсэн эрхийг хязгаарладаг төрийн албадлагын хамгийн хүнд төрөл мөн.

Түүхэн эх сурвалж, судалгааны бүтээлүүдээс үзвэл хорих ял манай орны хувьд өнөө үеийн утгаар XVIII зууны эхээр үүсч¹, нийтлэг байдлаар² XX зуунаас хэрэглэгдэж иржээ.

Хорих ял оногдуулах, түүнийг эдлүүлэх манай орны төрийн бодлогод XX зуунаас хойш зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй боловч энэ цаг үед эрүүгийн болон эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоо шинэтгэлийн шатандаа байна гэж хэлэх үндэслэлүүд байна.

Учир нь өнөөдөр нэг талаас хууль тогтоох байгууллага-УИХ-д гэмт хэрэгтэй тэмцэх салбарын эрх зүйн гол эх сурвалж болсон Эрүүгийн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Эрүүгийн ял эдлүүлэх ("Шүүхийн шийдвэр гүйцэтгэх") тухай хуулиуд өргөн баригдаж, зарим нь хэлэлцэгдэж байгаа, нөгөө талаас хорих ял эдлэгчдийн амьдрах орчин нөхцөлийг олон улсын стандарт, дэлхийн тэргүүлэх гүрнүүдийн жишигт ойртуулан нийцүүлэх эрх зүй-зохион байгуулалтын шинжтэй олон ажлыг ял эдлүүлэх практикт захиргааны байгууллагууд хийсэн, хийж зохих үр дүнд хүрч байна³.

Мөн хорих ялыг ялгамжтай эдлүүлэх эрх зүйн зохицуулалтын хүрээнд⁴ чанга

дэглэмтэй хорих 409, 413, онцгой дэглэмтэй хорих 439-р ангид давтан гэмт хэрэгтнүүд, өмнө нь удаа дараа хорих ял эдлэгчдийг анх удаагийн гэмт хэрэгтнээс, засарч хүмүүжиж байгаа ялтныг засрал олохгүй байгаа ялтаас тусгаарлан байрлуулж хорих ял эдлүүлэх бодит орчин нөхцөл тодорхой хэмжээнд бий болсон зэрэг баримтуудыг тэмдэглэе⁵.

Манай орны салбарын хууль тогтоомжид "ялтныг нийгэмшүүлэх", "хорих байгууллага дахь нийгмийн ажил" гэсэн нэр томьёо тусгагдаагүй боловч Эрүүгийн хуульд "... гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх ..." ⁶, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд "... ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх..." ⁷, "...ялтны дунд хүмүүжлийн ажил явуулах ..." ⁸, "... засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан ялтныг хугацаанаас нь өмнө тэнсэн суллах ..." ⁹ гэсэн тэдгээрийн агуулгыг хэсэгчлэн илэрхийлсэн нэр томьёо цөөнгүй бий.

Харин эрх зүйн дэд актуудын¹⁰ түвшинд олон улсын эрүүгийн ял эдлүүлэх салбарт өргөнөөр хэрэглэгддэг социализация (opoc), socialization (англи), sozialisierung (герман), ресоциализация, resocialization, resozialisierung, реабилитация, rehabilitation, social rehabilitation, rehabilitierung, sozialerehabilitierung, коррекция, исправление, адаптация гэсэн үг хэллэг-нэр томьёог илэрхийлсэн эсхүл тэдгээрийг төлөөлүүлэн хэрэглэсэн "ялтныг нийгэмшүүлэх", "ялтанд нийгмийн ажлын, сэтгэл зүйн, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх", "ялтны нийгэмд, бусдад, эрх зүйн нийтлэг журамд хүндэтгэлтэй хандах харьцааг төлөвшүүлэх", "ялтныг суллагдсаны дараа бие даан амьдрах дадал, чадварт

⁵ Ялтны тусгаарласан байр

⁶ Энэ хуулийн 45-р зүйлийн 3 хэсэг //www.legalinfo.mn

⁷ Энэ хуулийн 8-р зүйлийн 8.2.3 хэсэг //www.legalinfo.mn

⁸ Мөн хуулийн 123-р зүйл

⁹ Мөн хуулийн 126-р зүйл

¹⁰ Тухайлбал, ХЗДХ-ийн сайдын 2009 оны 199-р тушаалаар баталсан "Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр", ШШГЕГ-ын даргын 2009 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө" зэрэг /www.moj.gov.mn; www.cd.gov.mn/, бусад.



Хууль сахиулахуй

сургах” зэрэг үг хэллэг-нэр томьёо тусгагдан, хорих байгууллагын бие даасан үйл ажиллагаа-чиг үүрэг болон төлөвшин хэрэгжиж байна.

Иймд салбарын хэмжээнд энэ бүх ажиллагааг нийтэд нь “ялтны дунд явуулах нийгмийн ажил” гэсэн ерөнхий хэллэг-агуулгаар хэрэглэж хэвшсэнийг тэмдэглэе.

Нийгмийн ухааны болон хууль зүйн толь бичиг, мэргэжлийн судалгааны бусад бүтээлд¹¹ анализ хийн үзвэл:

-“социализация” буюу “нийгэмших”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томьёо нь хүмүүний нийтлэг үнэт зүйлс, ёс суртахуун, аж байдал, эрх зүйн дэг журмыг хүндэтгэн сахиж, зохицож амьдрах, түүнд хэвших ухамсарт үйл явц, зорилго чиглэл бүхий үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнг;

-“ресоциализация” нь нийгмийн үнэт зүйлс, журмыг үл ойшоон, санаатайгаар зөрчсөн гэм буруутай хүмүүний “алдаа оноог” ухааруулан ойлгуулах /ухамсарлуулах/, амьдралын зүй зохист бус хэв маяг, сэтгэхүй, сэтгэлгээг өөрчлөн засан төлөвшүүлэх үйл ажиллагааг,

-“коррекция” болон “исправление” нь “ресоциализация буюу өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болон эдгээр хүмүүсийн зан суртахуун-авир, харьцаа, сэтгэхүй, үг хэллэг, амьдралын гажуудал-эвдрэл, хэв маягийг нь засан өөрчлөх үйл ажиллагааг,

-“реабилитация” нь сэтгэц гэм судлал, анагаах ухааны үүднээс тухайн хүмүүсийн цочрол, эмгэгт өртсөн, гажуудсан, сэв суусан зан байдал, сэтгэл зүйг нөхөн сэргээх, өөрчлөх, өөртөө болон бусдад итгэх алдагдсан итгэл найдварыг бий болгох үйл ажиллагааг,

-“социальная работа”(“social work”) нь хүмүүсийг дэмжин туслах үйл ажиллагааг,

-“адаптация” (адаптирование) гэсэн

нэр томьёо нь иргэний, чөлөөт нийгэмд дасан зохицож, нийгмийн болон хувь хүний зэрэг үүрэг-хариуцлагаа ухамсарлах, бие даан амьдралаа авч явах дадал хэвшил, чадварт сурах, сургах үйл явцыг голлон илэрхийлдэг хэмээн судлаачийн зүгээс үздэг.

Иймээс эрүүгийн эрх зүйн журмыг зөрчсөн гэмт этгээдийг “нийгэмшүүлнэ” гэж ярихын зэрэгцээ “өөрчлөн (дахин) нийгэмшүүлэх” гэсэн нэр томьёог энэ салбарт хэрэглэвэл уг үйл ажиллагааны зорилго, агуулгыг илүү тодотгоно гэж үздэг.

Тэгээд ч тодорхой этгээдээс гэмт хэрэг, ялангуяа санаатай гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн, хүргэсэн гол шалтгаан нь түүний амьдралын таатай бус орчин нөхцөл, боловсрол, мэдлэг, сэтгэлгээний хоцрогдол, амар хялбар аргаар, бусдын хүчийг мөлжин хангалуун амьдрах хүмүүнлэг бус хүсэл эрмэлзэл, шунахайн сэдэл, сэтгэцийн эмгэг, гажуудал, зан суртахууны эвдрэл, амьдралдаа, өөртөө, бусдад итгэх итгэл алдарсан байдал, хоосон хийсвэр таамаглал, төөрөгдөл, бие даан амьдрах арга ухаан, чадварын дутмагшил зэрэг бусад объектив, субъектив хүчин зүйлс байдгийг хууль зүйн шинжлэх ухааны хавсарга салбар болох криминологийн ухаан нэгэнтээ нотолдог.

Мөн ял, түүний дотор хорих ял эдлэх үйл явцтай¹² уялдан дийлэнх ялтны нийгмийн эерэг, бодит хэлхээ холбоо тасрах, тасалдах, зан харьцаа, хэл яриа, сэтгэхүй, сэтгэц, амьдралын хэв маяг, аж байдал, эрүүл мэндэд нь сөрөг өөрчлөлтүүд гардгийг судалгааны баримтууд харуулдаг.

Иймд салбарын хүрээнд “хорих ял эдлэгчдийг нийгэмшүүлэх, өөрчлөн нийгэмшүүлэх”¹³ ажиллагаа зэрэгцээ байдлаар явагддаг гэсэн дүгнэлтийг судлаач хийж хууль тогтоомж, хууль зүйн практик, судалгааны бүтээлүүдэд эдгээр нэр томьёо-ухагдахууныг цаашид хэвшүүлэн хэрэглэхийг санал болгож

¹¹ Тухайлбал: Ж.Амарсанаа “”Англи-Орос-Герман-Монгол олон улсын эрх зүйн толь”, УБ.2004; С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ.2008; А.Я.Сухарев “Российская юридическая энциклопедия” М.1999; “Хорих байгууллага дахь нийгмийн ажил” сурах бичиг, УБ.2013, 2015 он зэрэг бусад.

¹² Нийтээс тусгаарлагдан, эрх чөлөө нь хязгаарлагдаж, гэмт хэрэг үйлдсэн хүмүүстэй хамт байж, тусгай цагийн хуваарийн дагуу, бусдаар удирдуулан амьдрах зэрэгтэй холбогдсон.

¹³ ресоциализация

байна.

II

Судалгааны бүтээл, гадаад орнуудын эрх зүйн холбогдох эх сурвалжид¹⁴ тулгуурлан үзвэл ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаа тэднийг хорих байгууллагад хүлээн авахаас эхлэн ял эдлэх бүхий л хугацааг хамран, суллахад бэлтгэх, суллах үйл явцаар дуусгавар болдог сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, анагаах, хууль зүй, нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай цогц арга хэмжээ юм.

Мөн энэ процесс түүний өмнөх буюу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатан дахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, мөн түүний дараах буюу ял хойшлосон, ялаас чөлөөлөгдсөн, тэнсэн харгалзсан, хорих байгууллагаас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаатай бүх талаар нягт уялдаа холбоо, үйлчлэлд оршин, хэрэгждэг ба гол үр дүн нь эдгээр хүмүүс дахин гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх явдлаар тодорхойлогддог байна.

Манай орны хувьд хорих ял эдлэгчдийг нийгэмшүүлэх, өөрчлөн нийгэмшүүлэх ажил хангалттай түвшинд явагдахгүй байгаа бөгөөд үүнийг дараах цөөн баримтаар төлөөлүүлэн илэрхийлж болно. Энэ нь:

- Сүүлийн 10 жилийн дунджаар авч үзвэл жилд 7200 гаруй хүн хорих ял эдэлж байгаа бөгөөд ойрын жилүүдэд энэ тоо буурахгүй хандлага ажиглагдахгүй байна¹⁵.

- Хорих байгууллагаас суллагдсан иргэдийн 47 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлддэг¹⁶.

¹⁴ Ресоциализация осужденных в условиях развития гражданского общества: сборник материалов международной научно-практической конференции (11-12 декабря 2014 г.). -г.Киров: ФКОУ ДПО Кировский ИПКР ФСИН России, 2014.-275с., Пенитенциарная система и общества: опыт взаимодействия: сборник материалов международной научно-практической конференции (15-16 мая 2014 г.). -г.Пермь: ФКОУ ВПО Пермский институт ФСИН России, 2014.-266 с. болон бусад эх сурвалж.

¹⁵ 1993 онд-6085 /100 мянган хүн амд-270 хорих ялтай хүн оногдож байна/, 1996 онд-6070 /265/, 1999 онд-6414 /271/, 2002 онд-7256 /296/, 2005 онд-6998 /274/, 2008 онд-7540 /287/, 2012 онд-8417 /296/, 2014 онд-8015 /274/ хүн хорих ял эдэлж байгаа судалгааны мэдээ бий. <http://www.prisonstudies.org/info/worldbrief/> 2015 оны 7-р сарын 01-ны хандалтаар.

¹⁶ “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт судалгааны тайлан, олон улсын эрдэм

•Хорих ял эдлэгчдээс үйлдэх зөрчил, гэмт хэрэг тооны хувьд буурахгүй байгаа, бүтэц (төрөл) нь өөрчлөгдөж, учруулах хор уршиг, аюул занал нь ч нэмэгдэж байна¹⁷.

Түүнчлэн манай судлаачид¹⁸, төр захиргааны байгууллагууд ч хорих байгууллага дахь нийгмийн ажлын үр нөлөө төлөвлөсөн түвшинд хүрэхгүй байгааг хүлээн зөвшөөрдөг¹⁹.

Ялтныг нийгэмшүүлэх, өөрчлөн нийгэмшүүлэх ажил нь олон талт үйл ажиллагааг хамардаг²⁰ тул илтгэлийн түвшинд тэдгээрээс ялтны бусадтай хийх уулзалт, захидал, утсаар харилцах,

шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.2013 он, х.236-237; Эрүүгийн хуулийн төсөл-эмхэтгэл //Эмхэтгэсэн: ХЗЯ, УБ.2015 оны 02 сар.

¹⁷ Хорих байгууллагын ажилтны тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байх, эсэргүүцэх, амь биед нь халдахь, заналхийлэх, энэ үйлдлийг хийхийг уриалах, сөрөг хандлагатай бүлэглэл байгуулах, согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хэрэглэх зэрэг гэмт хэрэг, зөрчлүүд тооны хувьд буурахгүй байна. //Хорих ял эдлэх явцад үйлдэж буй гэмт хэрэг, зөрчил: урьдчилан сэргийлэх, тэмцэх арга зам сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл; Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүлийн 2014 №04 /12/, 2015 оны №01 /13/, 02-03 /14-15/ болон бусад дугаараас зохих мэдээллийг авч болно.

¹⁸ Энэ чиглэлээр доктор Р.Оюунбадам, судлаач Б. Алтангэрэл, Ц.Очгэрэл, О.Пүрэвсүрэн, Г.Галсанжамц, О. Баяржаргал нарын цөөнгүй бүтээл байна. Мөн 2012-2015 онд доктор Н.Гантулга миний бие магистрын зэрэг горилсон суралцагчдын нилээдгүй дипломын ажлын удирдагч, шүүмжлэгчээр /тухайлбал: А.Намсаманд, Н.Анар, Б.Цолмон, Б.Содгэрэл болон бусад/ ажилласан, түүнчлэн “Ялтанд сахилгын шийтгэл хүлээлгэх асуудал”, “Монгол улсын хорих байгууллага дахь нийгмийн ажил: онцлог, тулгамдсан асуудал”, “Ялтныг өөрчлөн нийгмүүлэх зарим асуудлууд” зэрэг эрдэм шинжилгээний илтгэл-өгүүлэл бичиж ОХУ-ын Холбооны Ял эдлүүлэх Албаны харьяа Пермийн, Кировын дээд сургуулиас зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн, ХСИС-ийн “Хууль сахиулахуй”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” сэтгүүлд нийтлүүлсэн.

¹⁹ Энэ талаарх мэдээллийг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга, ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл /эмхэтгэсэн ХЗЯ, ШШГЕГ УБ.2012 он /; “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” /эмхэтгэсэн ХЗЯ, УБ.2015/ болон ШШГЕГ-ын жил тутмын тайлан мэдээнээс; www.cd.gov.mn сайтаас тус тус үзэж болно.

²⁰ Ялтныг нийгэмшүүлэх, өөрчлөн нийгэмшүүлэх ажил нь ялтанд боловсрол, мэргэжил олгох, мэдлэгийг өргөжүүлэх, сөрөг зан төлөв, харьцааг өөрчлөх, хөдөлмөрлөх хүсэл эрмэлзлийг бий болгох, татан оролцуулах, ур чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн эерэг хэлхээ холбоог бататгах, шинэчлэн тогтоох, хууль ёсны зан үйлийг дэмжих, эмнэлгийн, нийгмийн, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, суллахад бэлтгэх, иргэний нийгэмд бие даан амьдрах, чөлөөтэй харьцах, хувь хүний хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зэрэг олон талт харилцааг хамардаг.



Хууль сахиулахуй

чөлөө авахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт, практикийн зарим асуудлыг хөндөн судлаачийн байр суурь, санал бодлыг илэрхийллээ. Үүнд: Нэг. Уулзалт

Ялтны бусадтай хийх уулзалт тэдний нийгэмшил, өөрчлөн нийгэмшихэд онцгой байр эзэлдэг.

Гэмт хэрэгтэн, ялтны хувьд гэр бүл, төрөл садан, найз нөхөд, нийгмийн бусад гишүүдтэй чөлөөт харилцаанд оролцох явдал нилээд хязгаарлагдмал, тулгамдсан асуудалтай бөгөөд энэ нь объектив, субъектив олон хүчин зүйлээс хамааралтай²¹.

Манай орны хувьд ялтны бусадтай хийх уулзалтын эрх зүйн зохицуулалтын²² онцлогоос авч үзвэл, энэ нь:

0.1. Удаан хугацааны уулзалт

0.1.1. Удаан хугацааны уулзалт 72 цагаас дээшгүй хугацаагаар явагддаг²³.

0.1.2. Хорих ял эдэлж буй дэглэмээс хамааран ялтны удаан хугацааны уулзалтын тоо ялгамжтай байдаг²⁴.

0.1.3. Ялтан удаан хугацааны уулзалтыг төрөл садангийн хүмүүстэй хийнэ²⁵.

0.1.4. Удаан хугацааны уулзалтыг хорих байгууллагын нутаг дэвсгэр дэх уулзалтын байранд зохих хяналт шалгалтын дор хийдэг²⁶.

0.1.5. Гянданд ял эдэлж байгаа ялтан удаан хугацааны уулзалт авах эрх зүйн боломж байхгүй²⁷.

²¹ Энэ юуны өмнө гэмт хэрэгтэн, ялтан бие хүний криминологи шинж (тухайлбал, манай орны сүүлийн жилүүдийн статистик тоо баримтын дунджаар үзвэл гэмт хэрэгт холбогдогчдын 63 хувь нь ажил хөдөлмөр эрхлээгүй, 25 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 53 хувь нь 18-30 насны идэр залуус, хорих ял эдлэгчдийн 50 гаруй хувь нь өмнө хорих ял эдэлж байсан ба чанга, онцгой дэглэмд хорих ял эдлэгчдийн хувьд 70 хувь нь 1-8 удаагийн ял шийтгэлтэй зэрэг) болон нийгмээс тусгаарлагдсан, эрх чөлөө нь хязгаарлагдсан, бусад гэмт хэрэгтэн, ялтануудтай хамт байх, хатуу цагийн хуваарьт захирагдах, бусдын удирдлага заавраар ажил, амьдрал нь зохицуулагдах зэрэг хүчин зүйлсээр тодорхойлогддог.

²² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 119-р зүйл // www.legalinfo.mn

²³ Мөн хуулийн 119-р зүйлийн 119.2 хэсэг

²⁴ Мөн хуулийн 107-р зүйлийн 107.4 хэсэг, 108-р зүйлийн 108.2 хэсэг, 110-р зүйлийн 110.5 хэсэг, 110.6 хэсэг, 111-р зүйлийн 111.3, 111.4 хэсэг

²⁵ Мөн хуулийн 119-р зүйлийн 119.1 хэсэг

²⁶ Хууль зүйн сайдын 2014 оны А/230 дугаар тушаалаар баталсан "Хорих ангийн дотоод журам"-ын 11-р зүйл

²⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд энэ талаар зохицуулалт байхгүй тул нийтийн эрх зүйн хүрээнд "зөвшөөрснөөс бусдыг хориглоно" гэсэн эрх зүйн зарчмыг удирдлага болгон энэхүү хууль зүйн практик

0.1.6. Ялтны удаан хугацааны уулзалтыг түр хугацааны уулзалт, телефон утсаар ярих, хорих байгууллагаас гадагшаа чөлөөгөөр явахаар солих эрх зүйн боломж, зохицуулалт салбарын хуульд байхгүй²⁸.

0.2. Түр хугацааны уулзалт

0.2.1. Түр хугацааны уулзалт 3 цагаас дээшгүй хугацаагаар хорих ангийн эрх бүхий ажилтны хяналт дор явагдана²⁹;

0.2.2. Жирийн дэглэмд хорих ял эдэлж байгаа нийт ялтанд түр уулзалт тоон хязгаарлалтгүй³⁰;

0.2.3. Сахилгын байранд хоригдсон, тусгаарлах тасалгаанд шилжсэн ялтны ээлжит түр болон удаан хугацааны уулзалтыг хасахыг хориглоно³¹.

0.2.4. Түр хугацааны уулзалтыг ажлын өдрийн 10.00-17.00 цагийн хооронд зохион байгуулах бөгөөд хүчлэн хамгаалалт, өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед түр хугацааны уулзалтыг хязгаарлахгүй³².

0.2.5. Гяндангийн ялтны түр уулзалтыг шаланд бэхэлсэн хөлийн гав зүүсний дараа зохион байгуулна³³.

1.3. Захидал

Ялтны хязгаарлагдсан эрхийн нэг нь захидлаар харилцах явдал мөн. Манай орны энэ харилцааны эрх зүйн зохицуулалтын онцлог нь:

1.1. Хорих ял эдэлж буй дэглэмээс шалтгаалан ялтны захидлаар харилцах эрх зүйн боломж ялгамжтай тогтоогдсон. Үүнд: Онцгой дэглэмд ял эдэлж буй ялтан сард 2 удаа³⁴, гяндангийн ялтан сард 1 удаа³⁵, бусад ялтан тоон хязгаарлалтгүйгээр захидал илгээж

манай оронд тогтсон. // www.legalinfo.mn

²⁸ Харин Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны А/230 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Хорих ангийн дотоод журам"-ын 11.14-д "Чанга, онцгой дэглэмд ял эдэлж байгаа ялтны хүсэлтээр удаан хугацааны уулзалтыг түр хугацааны уулзалтаар сольж болно. Энэ тохиолдолд удаан хугацааны уулзалтад тооцогдоно" гэж заасан нь нэг талаас сайшаалтай боловч хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчмын үүднээс үүнийг зөвтгөх боломжгүй юм.

²⁹ Мөн хуулийн 119-р зүйлийн 119.2 хэсэг

³⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107-р зүйлийн 107.4 хэсэг

³¹ Мөн хуулийн 127-р зүйлийн 127.7 хэсэг

³² Хорих ангийн дотоод журмын 11.11 хэсэг

³³ Хорих ангийн дотоод журмын 4.2 зүйл

³⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 108-р зүйлийн 108.1 хэсэг

³⁵ Мөн хуулийн 109-р зүйлийн 109.4 хэсэг

болно³⁶.

1.2. Ялтны бусдаас захидал авах тоонд хязгаарлалт байхгүй³⁷.

1.3. Ялтны илгээх, ялтанд ирсэн захидалтай хорих байгууллагын эрх бүхий ажилтан танилцаж хориглосон зүйл илэрвэл хорих ангийн дарга, гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт эрхэлсэн дэд даргад танилцуулан тэмдэглэл үйлдэж хувийн хэрэгт нь хавсарган хадгална³⁸.

1.4. Хорих ял эдлүүлэх практикаас үзвэл 1990-ээд, ялангуяа 2002 оноос хойш ялтнаас захидал илгээх явдал эрс багассан ба үүнд тэдний бусадтай утсаар харилцах эрх, хууль зүйн практик голлох байдлаар нөлөөлсөн.

2. Утсаар ярих

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 онд батлагдан үйлчилж эхэлснээр ялтны утсаар ярих эрх хууль зүйн хувьд баталгаажин хэрэгжсэн.

Энэ харилцааны эрх зүйн зохицуулалтын онцлог нь:

2.1. Ялтан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу төрөл садантайгаа утсаар ярих эрхтэй³⁹. Гэхдээ энэ хэм хэмжээг томьёолсон хуулийн бичвэрийн оновчтой бус байдал нь хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх үүрэг бүхий субъектээс /хууль зүйн сайд/ энэ зохицуулалтыг гагцхүү төрөл садантайгаа хийхээр хязгаарлагдмал байдлаар журамласан гэж судлаач үздэг. Учир нь эрх зүйн нийтлэг зарчмыг баримтлан хуулийн тодорхой бус зохицуулалтыг холбогдогчид ашигтай байдлаар тайлбарлах ёстой.

2.2. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан өөрийн зардлаар таксофон ашиглах эрхтэй⁴⁰. Гэвч хууль зүйн сайдын баталсан "Хорих ангийн дотоод журам"⁴¹ хуулийн энэ зохицуулалтыг

өргөжүүлсэн гэж судлаач үздэг. Учир нь энэ журмын 13-р зүйлийн 13.1.1 "... чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж буй ялтан 7 хоногт, гяндангийн ялтан сард 1 удаа тус тус 09.00-17.00 цагийн хооронд 5 минутаас илүүгүй хугацаагаар суурин утсаар ярих" зохицуулалт бий болгосон.

3. Чөлөө

Хорих байгууллагаас гадагшаа гарах чөлөөний асуудал ялтны нийгэмшил болон түүнээс амин хувийн шинжтэй чухал асуудлыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой.

Манай орны хувьд энэ харилцааны эрх зүйн зохицуулалтын дараах онцлог байна. Энэ нь:

3.1. Чөлөөг гагцхүү жирийн дэглэмийн ялтанд олгоно⁴².

3.2. Ялтны төрөл садангийнх⁴³ нь хүн хүндээр өвчилсөн буюу нас барсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан тохиолдолд чөлөө олгоно⁴⁴.

3.3. Чөлөөг 7 хүртэл хоногийн хугацаагаар зохих нөхцөл байдал бий болсныг нотолсон сум, дүүргийн Засаг даргын болон эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн ял эдлүүлж байгаа хорих ангийн дарга шийдвэрлэж олгоно⁴⁵.

3.4. Чөлөөний хугацааг ялтны ял эдэлсэн хугацаанд оруулан тооцдог⁴⁶.

3.5. Ялтанд олгох чөлөөтэй холбогдсон нарийвчилсан зохицуулалтыг хууль зүйн сайдын 2014 оны А/230 дугаар тушаалаар баталсан "Хорих ангийн дотоод журам"-ын 16-р зүйлд мөн дараах байдлаар тусгасан.

3.5.1. Ялтанд чөлөөг хорих ангийн дарга тушаал гаргаж олгоно.

3.5.2. Чөлөө олгоход ялтны төрөл садангийн 2-оос доошгүй хүн ялтныг гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, чөлөөний хугацаа дуусмагц өөрийн биеэр буцаан авч ирэх, чөлөөний хугацаа дуусмагц хорих ангид

³⁶ Манай улсын хуульд энэ харилцааг зохицуулаагүй тул нийтийн эрх зүйн "зөвшөөрснөөс бусдыг хориглоно" зарчмыг баримталсан хууль зүйн практик тогтсон.

³⁷ Эрх зүйн дээрх зарчмыг мөн баримталдаг.

³⁸ Хорих ангийн дотоод журмын 12.1, 12.4, 12.5, 12.6, 12.7 зүйл. Хориглосон зүйл гэдгийг энэ журамд "... захидалд гэмт хэрэгт уриалсан, бусдыг гутаан доромжилсон, айлган сүрдүүлсэн, садар самууныг сурталчилсан, сэтгэл зүйг цочролд оруулж болзошгүй болон нууц тэмдэг, тусгай кодоор бичсэн мэдээлэл бүхий захидал..." байхаар тодорхойлсон.

³⁹ Хуулийн 115-р зүйлийн 115.6 хэсэг.

⁴⁰ Хуулийн 107-р зүйлийн 107.8 хэсэг.

⁴¹ Хууль зүйн сайдын 2014 оны А/23 дугаар тушаал

⁴² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107-р зүйлийн 107.5 хэсэг.

⁴³ Мөн хуулийн 119-р зүйлийн 119.1 хэсэгт "төрөл садан гэдэгт эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн болон хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, нэг ам бүлд хамт амьдардаг ач, зээ"-г хамруулан тодорхойлсон.

⁴⁴ Мөн хуулийн 107-р зүйлийн 107.5 хэсэг.

⁴⁵ Мөн хуулийн 107-р зүйлийн 107.6 хэсэг.

⁴⁶ Мөн хуулийн 107-р зүйлийн 107.7 хэсэг.



ХҮҮЛЬ
САХИУЛАХУЙ

буцаж ирээгүйгээс хорих байгууллагад учирсан зардлыг бүрэн хариуцна гэсэн үүрэг хүлээн батлан даалт гаргана.

3.5.3. Ялтан чөлөөний хугацаанд өдөрт ажлын цагаар нэг удаа нийслэлд байрлаж байгаа бол ШШГЕГ-ын жижүүрт, орон нутагт бол аймаг, сум дахь Шийдвэр гүйцэтгэх албанд бүртгүүлэх үүрэг хүлээнэ.

3.5.4. Бүртгүүлээгүй, оршин суух газартаа байгаагүй, эсхүл согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн бол чөлөөг даруй зогсоож тухайн ялтанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан сахилгын шийтгэл ноогдуулна.

3.5.5. Ялтанд эрүүгийн өөр хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа, эсхүл ял эдэлж байхдаа дахин гэмт хэрэг үйлдэж шийтгэгдсэн, оргохыг завдсан, зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн, урьд чөлөө авсан үндэслэлээр дахин хүсэлт гаргасан, чөлөө авах үндэслэл болсон баримт бичиг зөрчилтэй бол чөлөө олгохыг хориглоно.

Одоо ялтны уулзалт, захидал, утсаар ярих, хорих байгууллагаас гадагш чөлөөгөөр явахтай холбогдсон олон улсын эрх зүйн хэм хэмжээ, гадаадын зарим орны зохицуулалтын онцлогийг авч үзье.

III

Олон улсын эрх зүйн зохицуулалт

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр хурлаар баталж Эдийн засаг, Нийгмийн зөвлөлийн 1957 оны 663 С (XXIV), 1977 оны 2076 (LXII) тогтоолоор сайшаасан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-ийн 37-р зүйлд: “Хоригдлуудад тогтмол цаг хугацаанд, зохих хяналтын дор гэр бүлийнхэнтэйгээ болон нэр төрдөө сэв суулгаагүй найз нөхөдтэйгөө захидлаар харилцах, биечлэн уулзаж харилцах боломж олгож байвал зохино” гэж заажээ⁴⁷.

Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын

анхаарал татсан асуудал

Гадаадын орнуудын энэ харилцааны

эрх зүйн зохицуулалтын онцлогийг бидэнтэй олон шинжээрээ адил төстэй ОХУ, Казахстан Улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд⁴⁸ тулгуурлан товч авч үзье.

Удаан хугацааны уулзалт

а) Төрөл

Эдгээр оронд ялтны удаан хугацааны уулзалт Засан хүмүүжүүлэх байгууллагын⁴⁹ нутаг дэвсгэрт болон хуульд тусгайлан заасан тохиолдолд түүний гадна хийх зохицуулалт байдаг ба сүүлийн тохиолдолд тухайн байгууллагын дарга уулзалт хийх газар, дэг журмыг тодорхойлдог⁵⁰.

б) Үргэлжлэх цаг хугацаа

Хүмүүжлийн колоний нутаг дэвсгэрийн гаднах удаан хугацааны уулзалт 5 хоног үргэлжлэх боломжтой⁵¹.

в) Уулзалтын хязгаарлалт

Хорих ял эдлэгчдийн нийгэмших объектив хэрэгцээ, зорилгыг харгалзан “... жирийн дэглэмтэй гяндангийн”⁵² ялтанд удаан хугацааны уулзалт жилд 2 удаа хийхийг зөвшөөрдөг...⁵³.

Харин “... торгуулийн тусгаарлах байранд хорих ял эдэлж буй ялтанд уулзалт хийх, утсаар ярих, хүнсний бүтээгдэхүүн худалдан авах, илгээмж, мөнгөн гуйвуулга хүлээн авахыг хориглодог...”⁵⁴

⁴⁸ Энэ хууль 1997 оны 01-р сарын 08-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна. www.consultant.ru, www.online.zakon.kz цахим хаягаас 2015 оны 07-р сарын 01-ний хандалтаар мэдээллийг авсан. Орос хэлнээ энэ хууль “Уголовно исполнительный кодекс РФ” гэж бичигдэх бөгөөд үүнийг Эрүүгийн ял эдлүүлэх /үгчилбэл Эрүүгийн ялын гүйцэтгэлийн/ хууль гэж орчуулсан.

⁴⁹ Орос хэлнээ “Исправительное учреждение”, Казахстан улсын тухайд хорих ял эдлэх газар “Место исполнения наказания в виде лишения свободы”, “Учреждение” гэж бичигддэг.

⁵⁰ ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 132-р зүйлийн 1 хэсэгт зааснаар “... Хүмүүжлийн колони нь ял эдлэх нөхцөлөөрөө энгийн /жирийн/, хөнгөрүүлсэн, хөнгөн, чанга /хатуу/ гэж хуваагдах...” ба 133-р зүйлийн 2 хэсгийн дагуу “...удаан хугацааны уулзалтыг хүмүүжлийн колоний хөнгөрүүлсэн нөхцөлд ял эдэлж байгаа насанд хүрээгүй ялтны хувьд байгууллагын гадна хийх...” зохицуулалт үйлчилж байна. www.consultant.ru; Мөн ийм зохицуулалтыг Казахстан Улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 106-р зүйлд тусгажээ. www.online.zakon.kz

⁵¹ ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 89-р зүйлийн 1 хэсэг.

⁵² Дурдсан хуулийн 130-р зүйлийн 2 хэсэгт зааснаар хорих ял эдлэх газар онцгой байгууллага болох гяндан жирийн, чанга дэглэмд хуваагдана. Мөн

⁵³ Хуулийн 131-р зүйлийн 4 хэсгийн “б” заалт

⁵⁴ Дурдсан хуулийн 118-р зүйлийн 1 хэсэг

⁴⁷ Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол, шийдвэрийн эмхэтгэл. УБ.2014 он, х.84 //эмхэтгэсэн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс

г) Уулзалтын тоо

Ял эдэлж буй нөхцөл, дэглэмээс шалтгаалан ялтны удаан хугацааны уулзалт авах тоо ялгаатай⁵⁵. Тухайлбал: Ялтан жилд

-жирийн дэглэмтэй колоний ердийн нөхцөлд 4 удаа⁵⁶, хөнгөрүүлсэн нөхцөлд 6 удаа⁵⁷, хатуу нөхцөлд 2 удаа⁵⁸;

-чанга дэглэмтэй колоний ердийн нөхцөлд 3 удаа⁵⁹, хөнгөрүүлсэн нөхцөлд 4 удаа⁶⁰, хатуу нөхцөлд 1 удаа⁶¹;

-онцгой дэглэмтэй колоний ердийн нөхцөлд 2 удаа⁶², хөнгөрүүлсэн нөхцөлд 3 удаа⁶³;

-гяндангийн жирийн дэглэмд 2 удаа⁶⁴ тус тус удаан хугацааны уулзалт хийхийг зөвшөөрчээ.

Тэгвэл колони-тосгоны⁶⁵ ялтан тоон хязгаарлалтгүйгээр уулзалт хийх боломжтой⁶⁶.

Мөн энэ хуулийн дагуу урамшууллын журмаар нэмэлт удаан эсхүл түр хугацааны уулзалтыг нийт хорих ял эдлэгчидэд олгож болно⁶⁷.

д) Уулзалтыг солих

Ялтны хүсэлтээр удаан хугацааны уулзалтыг түр уулзалтаар, телефон утсаар ярихаар, хүмүүжлийн колонид ял эдлэгчдийн хувьд байгууллагын нутаг дэвсгэрээс гадагшаа гарах түр хугацааны уулзалтаар солих зохицуулалт байдаг ба энэ журмыг эрүүгийн ял эдлүүлэх салбарын төрийн

бодлогыг боловсруулах, хэм хэмжээний зохицуулалтыг хэрэгжүүлэгч гүйцэтгэх засаглалын Холбооны байгууллага тогтооно⁶⁸.

е) Уулзалтад хамрагдах хүмүүс

Ялтны удаан хугацааны уулзалтыг эхнэр/нөхөр, эцэг, эх, хүүхэд, үрчлэгч, үрчлүүлсэн хүмүүстэй, төрсөн ах, эгч, дүү, өвөө, эмээ, ач, зээтэйгээ болон засан хүмүүжүүлэх байгууллагын даргын зөвшөөрснөөр бусад хүмүүстэй хамт амьдрахаар зохион байгуулах боломжтой⁶⁹.

Түр уулзалт

а) 4 цаг үргэлжилнэ⁷⁰;

б) Ялтны хүсэлтээр түр хугацааны уулзалтыг телефон утсаар ярихаар солих зохицуулалт бий⁷¹;

в) Сахилгын шийтгэлийн журмаар хатуу тасалгаа бүхий байр, хатуу тасалгаатай нэгдсэн байр эсхүл ганцаарчилсан тасалгаанд шилжсэн ялтан хорих байгууллагын захиргааны зөвшөөрлөөр 6 сарын хугацаанд 1 түр уулзалт хийх эрхтэй⁷²;

г) Хорих ял эдлэх нөхцөлөөс хамаараад нэг дэглэмийн доторх ялтнуудын түр хугацааны уулзалтын тоо өөр өөр байдаг⁷³.

Захидал⁷⁴

⁶⁸ Хуулийн 89-р зүйлийн 3 хэсэг /өөрөөр хэлбэл ФСИН буюу Ял эдлүүлэх Холбооны алба/

⁶⁹ Хуулийн 89-р зүйлийн 2 хэсэг

⁷⁰ Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 89-р зүйлийн 1 хэсэг

⁷¹ Мөн хуулийн 89-р зүйлийн 3 хэсэг. Казахстан улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд хорих ял эдлэгчдийн түр хугацааны уулзалтын а/ үргэлжлэх хугацаа 2 цаг, б/ хорих байгууллагын төрөл, ял эдлэх нөхцөлөөс хамааран, тухайлбал, насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын дунд түвшиний байгууллагын ердийн нөхцөлд жилд 8 удаагийн, хөнгөвчилсөн нөхцөлд 24 удаагийн, хөнгөн нөхцөлд түр, удаан хугацааны уулзалтыг тооны хязгаарлалтгүй, хатуу нөхцөлд 6 удаагийн түр уулзалт хийх эрхтэй, в/ урамшууллын журмаар нэмэлт түр уулзалт олгодог.

⁷² Мөн хуулийн 118-р зүйлийн 2 хэсгийн "г" заалт

⁷³ Жишээ нь: Хуулийн 123-р зүйлд зааснаар "... чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх байгууллагын ердийн нөхцөлд ял эдэлж буй ялтанд жилд 3 удаагийн, хөнгөвчилсөн нөхцөлд -4 удаагийн, хатуу нөхцөлд-2 удаагийн түр уулзалт хийхийг ...", мөн хуулийн 133-р зүйлийн дагуу "...насанд хүрээгүйчүүдийн хүмүүжлийн колоний ердийн нөхцөлд ял эдлэгчид жилд 8 удаагийн, хөнгөвчилсөн нөхцөлд 12 удаагийн, хөнгөн нөхцөлд тоон хязгаарлалтгүйгээр түр хугацааны уулзалт хийхийг тус тус зөвшөөрдөг" байна.

⁷⁴ Мөн хуулийн 91-р зүйл. "Хорих ялтны захидал харилцаа"



Энэ институцийн зарим онцлогоос дурдвал:

а) Ялтан өөрийн зардлаар захидал, цахилгаан мэдээг тоон хязгаарлалтгүйгээр авах, илгээхийг зөвшөөрсөн.

б) Засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаа ялтны захидал хүлээн авах, илгээх болон захидал, цахилгаан мэдээнд хяналт тогтооно.

в) Шүүх, прокурор, Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны дээд байгууллага, ОХУ, түүний субъект дэх хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгч, ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан олон нийтийн ажиглах /хянах/ комисс, хүний эрхийн Европын шүүхэд хандсан ялтны захидал харилцаанд хяналт хязгаарлалт тогтоохгүй.

г) Ялтны өмгөөлөгч болон хуулийн үндсэн дээр хууль зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх бусад хүнтэй захидлаар харилцах явдалд засан хүмүүжүүлэх байгууллагын зүгээс хэрэв захидалд гэмт хэргийг санаачлах, төлөвлөх, зохион байгуулах эсвэл түүнд бусад хүнийг татан оруулахтай холбогдсон мэдээлэл байна гэсэн үндэслэл бүхий сэжиг байгаагаас бусад тохиолдолд хяналт хязгаарлалт тогтоохгүй. Энэ тохиолдолд засан хүмүүжүүлэх байгууллагын дарга эсвэл түүний орлогчийн үндэслэл бүхий тогтоолоор шуудангийн илгээлт, захидал, цахим болон бусад мэдээнд шалгалт хийж болно.

д) Засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдэлж байгаа төрөл садангийн бус ялтан өөр хоорондын захидал харилцааг засан хүмүүжүүлэх байгууллагын захиргааны зөвшөөрлөөр хийж болно.

Утсан харилцаа⁷⁵

Энэ институцийн онцлог зохицуулалтаас дурдвал:

а) Засан хүмүүжүүлэх байгууллага дахь техникийн боломжгүй нөхцөлд утсаар ярих явдлыг жилд 6 хүртэл хязгаарлаж болно.

б) Нэг удаагийн утсан харилцаа 15 минутаас хэтрэх ёсгүй.

в) Утасны төлбөрийг ялтан өөрөө эсвэл төрөл садан, бусад хүмүүс хийнэ.

г) Утсаар ярих журмыг засан хүмүүжүүлэх байгууллагын харьяалалд нь багтдаг гүйцэтгэх засаглалын

Холбооны байгууллага тодорхойлно.

д) Ялтан засан хүмүүжүүлэх байгууллагад ирснээр, мөн тэдэнд хувийн онцгой нөхцөл байдал үүсвэл хүсэлтийг нь үндэслэн утсаар ярих боломж олгоно.

е) Хорих ял эдлэх хатуу нөхцөлд байгаа, сахилгын шийтгэлийн журмаар торгуулийн тусгаарлах байр, сахилгын тусгаарлах байр, хатуу тасалгаат байр, хатуу тасалгаат нэгдсэн байр, мөн ганцаарчилсан тасалгаанд хоригдож буй ялтны хувийн онцгой нөхцөл байдлын үед утсаар ярихыг зөвшөөрч болно.

ё) Засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдэлж байгаа ялтнууд хооронд утсаар ярихыг хориглоно. Онцгой тохиолдолд засан хүмүүжүүлэх байгууллагын даргын зөвшөөрлөөр хорих ял эдэлж байгаа төрөл садантайгаа утсаар ярихыг зөвшөөрнө.

ж) Утсаар ярихад засан хүмүүжүүлэх байгууллагын ажилтан хяналт тавина.

Чөлөө⁷⁶

Энэ институцийн онцлог нь:

а) Засан хүмүүжүүлэх колони, хүмүүжлийн колонид хорих ял эдэлж байгаа, тэрчлэн цагдан хорих байр, гяндангийн ахуйн үйлчилгээний ажлыг тогтоосон журмын дагуу хийж буй ялтанд засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагш чөлөөгөөр явахыг зөвшөөрдөг. Энэ нь:

-Хувийн онцгой шалтгаанаар /ойрын төрөл садан нас барсан, эсвэл нас барах аюулд хүргэх хүнд өвчтэй, мөн ялтан, түүний гэр бүлд байгалийн гамшгийн улмаас материалын үлэмж хор хөнөөл учирсан/, тэрчлэн суллагдсаны дараах хөдөлмөрлөх болон орон байрны асуудлаар урьдчилан шийдвэрлэх зорилгоор очих, буцах хугацааг оролцуулалгүй 7 хүртэл хоногоор богино хугацаатай чөлөө

-Жил бүрийн цалинтай амралтын хугацаанд нийт ялтнууд, мөн хүсэлтээрээ хөдөлмөрлөсөн 60-ээс дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй, тахир дутуугийн 1, 2-р групптэй болон насанд хүрээгүй ялтан, тэрчлэн өөрөөс

⁷⁵ Хуулийн 92-р зүйл.

⁷⁶ Хуулийн 97-р зүйл.



нь хамааралгүй шалтгаанаар ажил хөдөлмөрөөр хангагдаагүй ялтанд жил тутмын цалинтай амралтын хугацаанд удаан хугацааны чөлөө зөвшөөрнө.

б/ Засан хүмүүжүүлэх колоний ясли-цэцэрлэгт хүүхэд нь байгаа эмэгтэй ялтанд хүүхдээ төрөл садангийн дэвсгэл ясли-цэцэрлэгт өгөх асуудлыг зохицуулахаар гадагшаа гарахад нь богино хугацааны 15 хүртэл хоногийн чөлөөг явах, ирэх хоногийг оролцуулалгүй, тэрчлэн эмэгтэй ялтанд засан хүмүүжүүлэх колоний гадна байгаа насанд хүрээгүй тахир дутуу хүүхэдтэйгээ уулзахад нь жилд нэг удаа мөн хугацаагаар чөлөөгөөр явахыг зөвшөөрнө.

в/ Гадагш гарах чөлөөг онц аюултай рецидив гэмт хэрэгтнээр тооцогдсон, цаазаар авах ялыг хорих ялаар сольсон, бүх насаар хорих ялтай, ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, халдварт өвчин, согтуурах, мансуурах явдлыг эмчлэх эмчилгээнд бүрэн хамрагдаагүй, мөн ДОХ-той ялтнууд, тэрчлэн халдварын эсрэг арга хэмжээ зохион байгуулж байгаа үед олгохыг зөвшөөрөхгүй.

г/ Ял эдлэх чадварыг үгүйсгээгүй сэтгэцийн сааталд орсон өвчтэй, тахир дутуугийн 1, 2-р групптэй, эрүүл мэндийн улмаас бусдын халамж шаардлагатай, тэрчлэн насанд хүрээгүй ялтанд засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагшаа чөлөөгөөр явахыг төрөл садан, эсвэл бусад дагалдан явах хүний хамт зөвшөөрнө.

д) Хувийн онцгой шалтгаанаар чөлөө авах ялтны хүсэлтийг нэг хоногийн дотор хэлэлцэх ёстой. /98-р зүйлийн 5 хэсэг/

е) Засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагш явах чөлөөний зөвшөөрлийг ялтны үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, төрөл, ял эдэлсэн хугацаа, хувийн байдал, зан төлөвийг харгалзан байгууллагын дарга өгнө. /98-р зүйлийн 6 хэсэг/

ё) Зөвшөөрөгдсөн хугацаанд засан хүмүүжүүлэх байгууллагад ирэх явдалд нь урьдчилан хараагүй шалтгаалах нөхцөл үүссэн үед ялтны байрлаж байгаа Дотоод хэргийн байгууллагын

даргын тогтоолоор 5 хүртэл хоногоор чөлөөний хугацааг сунгаж болох ба энэ талаар тухайн байгууллага нэн даруй засан хүмүүжүүлэх байгууллагын захиргааг зайлшгүй мэдээллээр хангана. /98-р зүйлийн 9 хэсэг/

ж) Засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагшаа гарах ялтны чөлөөтэй холбогдсон харилцааг засан хүмүүжүүлэх байгууллагын дотоод журмаар тодорхойлно. /98-р зүйлийн 10 хэсэг/

з) Тогтоосон хугацаанд ялтан засан хүмүүжүүлэх байгууллагад буцаж очихоос зайлсхийсэн тохиолдолд прокурорын зөвшөөрлөөр байрлаж буй Дотоод хэргийн байгууллага түүнийг ял эдлэх засан хүмүүжүүлэх байгууллагад хуяглан хүргэх эсхүл эрүүгийн хариуцлагад татах асуудлыг шийдвэрлэхээр 30 хоногоос хэтрүүлэлгүйгээр саатуулна. /98-р зүйлийн 11 хэсэг/

и) Гадаад улсын нутаг дэвсгэрт чөлөөгөөр явах асуудлыг холбогдох улстай байгуулсан хэлэлцээрт заасан журмын дагуу зөвшөөрнө. /98-р зүйлийн 12 хэсэг/

ДҮГНЭЛТ, САНАЛ

Ялтныг нийгэмшүүлэх, өөрчлөн нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалт, хууль зүйн практикийн үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр манай оронд 1990-ээд оноос, ялангуяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр олон дэвшилтэт арга хэмжээг авсан, хийхээр төлөвлөж буй боловч⁷⁷ олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээ, гадаадын орнуудын ололттой жишгийг харгалзсан эрх зүйн дараах зайлшгүй өөрчлөлтийг хийх шаардлага байна гэсэн дүгнэлт хийж дараах саналуудыг дэвшүүлж байна. Энэ нь:

1. Уулзалт

1.1. Удаан хугацааны уулзалтыг ялтны хүсэлтээр түр хугацааны уулзалт, утсаар харилцах явдлаар солих эрх зүйн

⁷⁷ УИХ-д өргөн баригдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хууль зүйн яам, ШШГЕГ-аас баримталж буй бодлогын баримт бичиг



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

боломжийг бий болгох. Мөн уулзалтыг цахим техникийг ашиглан бие биеэ харж ярилцах зохицуулалттай болгох.

1.2.Уулзалтын байрны орчин нөхцөлийг ялтанд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх, ялтныг нийгэмшүүлэх зорилготой уялдуулан шинэчлэх шаардлагатай ба энэ нь юуны өмнө уулзалтын байрны багтаамж, ая тух, эд хогшил, тохижуулалттай холбоотой. Тухайлбал, удаан хугацааны уулзалтын байрыг хүүхэд хичээллэх, тоглох өрөө тасалгаатай болох, уулзалт хийж байгаа хүмүүс усанд орох, спортоор хичээллэх, тодорхой хэмжээнд зугаалах боломжийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх зэрэг.

1.3.Түр уулзалтын үргэлжлэх хугацааг 5 хүртэл цаг болгон нэмэгдүүлэх.

1.4.Ялтны эерэг зан байдал, төлөвшлийг дэмжих чиглэлээр урамшууллын журмаар ялтанд нэмэгдэл удаан, түр хугацааны уулзалт олгох.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх (127-р зүйлийн 127.1.1)"... сахилгын шийтгэлийн журмаар ялтны түр, удаан хугацааны уулзалтын тоог бууруулах" асуудлыг дахин нягтлан илүү тодорхой зохицуулалттай болгох шаардлагатай. Учир нь урамшууллын журмаар олгогдсон нэмэгдэл түр, удаан хугацааны уулзалтыг сахилгын шийтгэлийн хэлбэрээр хасах зохицуулалт байх боломжтой болохоос бус ялангуяа хаалттай хорих ангид ял эдэлж буй ялтны ээлжит уулзалтыг хасах нь сөрөг үр дагаварыг бий болгоно хэмээн үзэж байна.

1.5.Өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд гянданд ял эдэлж байгаа ялтан удаан хугацааны уулзалт хийх боломжгүй тул түүнийг бий болгох. Учир нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтны энэ эрхийг хүлээн

зөвшөөрөөгүй боловч ялтан гянданд сахилгын зөрчлийн учир дэглэм дээшилж ирсний дараах үед хугацаа дуусч, мөн өвчний учир ялаас чөлөөлөгдөн суллагдах нь эрх зүйн зохицуулалтын хувьд боломжтой тул суллагдах ялтны нийгэмших зайлшгүй хэрэгцээ шаардлагыг харгалзан үүнийг бий болгох ёстой.

2.Утсан харилцаа

2.1.Ялтан төрөл садантайгаа болон түүнд эерэг байдлаар нөлөөлөх бусад хүнтэй утсаар ярих эрх зүйн боломжийг бий болгох.

2.2.Утсаар ярих явдлыг ялтны зүгээс болон түүний төрөл садан, бусад хүн санаачлан зохих журмын дагуу хийх, төлбөрийг хариуцах боломжийг бий болгох.

2.3.Цахилгаан мэдээ илгээх эрх зүйн зохицуулалт өнөөгийн хууль тогтоомжид байхгүй тул үүнийг бий болгон хуульчлах.

3.Захидал

3.1.Захидлын олон талт ач холбогдлыг⁷⁸ харгалзан тоон хязгаарлалтгүй болгох.

3.2.Захидлыг бичгээр, цахим техник хэрэгсэл ашиглан илгээх явдлыг хуульчлах.

4.Чөлөө

4.1.Чөлөөний төрөл, зохицуулалтыг ОХУ-ын жишгийг харгалзан хуулийн түвшинд өргөжүүлэх, нарийвчлан тодотгох. Тухайлбал,

-гэртээ амралтын журмаар, мөн хүүхэдтэйгээ уулзах, суллагдсаны дараах орон байр, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаа шийдвэрлэхтэй холбогдсон чөлөөг бий болгох, чөлөөний хугацааг ялтны очиж ирэх засаг захиргааны нэгжийн байршил, зам тээврийн хангамж, хүртээмж зэрэг бусад нөхцөлүүдтэй нь уялдуулан хуульчлах зэрэг болно.

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн эрхлэгч, доктор, профессор, дэд комиссар Б.Бат-Эрдэнэ**

⁷⁸ Тухайлбал: бичих, унших, дахин унших, бичгийн хэлбэрийг сайжруулах, мэдээлэл авах, эргэцүүлэн бодох, сууж сурах, харьцааны эерэг үг хэллэг-ярианы эв дүйтэй, зөв боловсон харьцаж сурах зэрэг.